



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 8/135

Мөрөн сум

Автотээврийн хэрэгслийн техникийн
хяналтын үзлэгийг сумдад зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, бүртгэлийг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. 2023 оны автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, бүртгэлийг зохион байгуулах аймгийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумдад тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг тооллого явуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сум,багт байгаа автомашин, чиргүүл, трактор өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн бүртгэл судалгааг гаргах, техникийн үзлэгт тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах зэрэг ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын салбар комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Авто тээврийн хэрэгслийн явуулын техникийн хяналтын үзлэгийн үеэр тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг хийх, мотоциклд улсын дугаар олгох, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, бүртгэлийг хийх, ашиглахаа больсон боловч улсын бүртгэлийн санд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах эсэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн ажиллахыг Автотээврийн төвийн дарга (Ө.Баттулга)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.


ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6710010075



Комиссын дарга:

М Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд :

Ө.Баттулга (Аймгийн Автотээврийн төвийн дарга)

А.Алтанцоож (Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Ч.Хуншагай (Аймгийн Татварын хэлтсийн дарга)

Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг дарга)

Б.Батбаатар (Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, ахмад)

Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Х.Бямбадорж (Аймгийн Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер)

___оОо___

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 13-ны өдрийн
7/135 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

РЮА0007 9070354

СУМДАД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ
ТООЛЛОГО ЯВУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Нэгдүгээр чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Тосонцэнгэл	Автотээврийн төвийн ажлын хэсэг /6 хүний бүрэлдэхүүнтэй/	4/12-13	450	2 хоног
2	Рашаант		4/14-15	500	2 хоног
3	Их-Уул		4/16-17	480	2 хоног
4	Тариалан		4/18-21	800	4 хоног
Нийт				2,230	10 хоног
Д/д	Хоёрдугаар чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Эрдэнэбулган	Автотээврийн төвийн ажлын хэсэг /6 хүний бүрэлдэхүүнтэй/	4/24-26	380	3 хоног
	Чандмань-Өндөр		4/27-28	290	2 хоног
2	Цагаан-Үүр		4/29-30	187	2 хоног
3	Түнэл		5/01-02	406	2 хоног
нийт				1,263	9 хоног
Д/д	Гуравдугаар чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Төмөрбулаг	Автотээврийн төвийн ажлын хэсэг /6 хүний бүрэлдэхүүнтэй/	5/05-06	370	2 хоног
2	Шинэ-Идэр		5/07-08	280	2 хоног
3	Галт		5/09-10	500	2 хоног
4	Жаргалант		5/11-13	670	3 хоног
Нийт				1,820	10 хоног
Д/д	Дөрөвдүгээр чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Могойн гол	Автотээврийн төвийн ажлын хэсэг /6 хүний бүрэлдэхүүнтэй/	5/15	680	1 хоног
2	Цэцэрлэг		5/16-17		2 хоног
3	Цагаан-Уул		5/18-21	930	4 хоног
4	Бүрэнтогтох		5/22-24	630	3 хоног
Нийт				2,240	10 хоног
Д/д	Тавдугаар чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног
1	Баянзүрх	Автотээврийн төвийн ажлын хэсэг /6 хүний бүрэлдэхүүнтэй/	5/29-30	280	2 хоног
2	Улаан-Уул		5/31-6/02	400	3 хоног
3	Ренчинлхүмбэ		6/03-04	368	2 хоног
4	Цагааннуур		6/05-06	140	2 хоног
Нийт				1,188	
Д/д	Зургаадугаар чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах хоног

1	Арбулаг	Автотээврийн төвийн ажлын хэсэг /6 хүний бүрэлдэхүүнтэй/	6/09-10	550	2 хоног
2	Алаг-Эрдэнэ		6/11-12	450	2 хоног
3	Хатгал		6/13-15	450	2 хоног
	Ханх		6/16-19	150	3 хоног
НИЙТ					11 хоног

_____оОо_____